



“ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК-ийн
ЗАХИРАЛ Н.ОДОНБИЛЭГ ТАНАА

“СARУУЛ БАЯН УУЛ-АУДИТ” ХХК

Утас: 99093852, 89383852

2022.03.15 № 111

танай _____-ны № _____-г

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн мэдээллээс бүрдсэн “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК-ийн санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайланг бүхий л материаллаг асуудлаар Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Санхүүгийн тайлангийн аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагыг бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаархи хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материалаг буруу илэрхийлэлийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчийн шийдвэрт нөлөөлөх бол материаллагт тооцогддог.

Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргадаг.

